



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 19/349

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 3 дугаар
сургуулийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 10,140,000.00 /арван сая нэг зуун дөчин мянга/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургууль /В.Хоролгарав/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургууль /В.Хоролгарав/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /С.Ариунжаргал/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын
даргын 2019 оны 09 сарын 20 өдрийн А.1.349
дугаар тушаалын хавсралт



Хандивын хөрөнгө бүртгэлд авах тухай санал

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Хандивлагч /байгууллага/	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
1	Сурагч ширээ сандал/хос/	Төмөр хөлтэй модон	Монгол	2019	сайн	ш	52	195,000	10,140,000	Эцэг эх	хандив
Нийт дүн									10,140,000		